

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн №01 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн № 01 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгосугай.

2. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ердийн гишүүнээр:

1. Д.Ганбаатар
2. Д.Цэрэнжигмэд
3. Б.Түвшинтөгс
4. Д.Жамъян
5. Д.Уянгалянхуа
6. Ц.Соёл-Эрдэнэ
7. Д.Тунгалаг
8. Ш.Батжаргал

Хараат бус гишүүнээр:

1. Н.Цэрэндорж
2. Ш.Даваалимбэ
3. Г.Баяр
4. П.Мэндсайхан

ХУРЛЫН ДАРГА

Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн № 01 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг дараах байдлаар тогтоож, 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн, улирал тутамд 1 удаа тооцон олгосугай. Үүнд:

№	Албан тушаал	Улирал тутамд олгох цалин, урамшууллын хэмжээ /Төгрөг/
1.	ТУЗ-ийн дарга	5,000,000 /Таван сая/
2.	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүн	1,000,000 /Нэг сая/

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллыг тогтоосон хэмжээгээр, улирал болгон тооцон олгохыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/ болон Санхүүгийн алба /А.Цагаансар/-нд тус тус зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ